# ДУНДГОВЬ АЙМГИЙН
# ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
# ТОГТООЛ

2018 оны 12 сарын 10 өдөр Дугаар 120 Мандалговь

Хөрөнгө акталж, данснаас хасах
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3 дахь хэсэг, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2018 оны 77 дугаар тогтоолоор батлагдсан "Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсгийн 6.2.1, 6.4 дахь хэсгийн 6.4.1 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлаас ТОГТООХ НЬ:

Нэг: Зоонозын өвчин судлалын төвийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 500,000.00 (таван зуун мянга) төгрөгийн Canon Sharp AR-158X канoныг сэлбэг материал болгон эргэлтийн хөрөнгөд бүртгэхийг, 2,320,757.00 (хоёр сая гурван зуун хорин мянга долоон зуун тавин долоо) төгрөгийн балансын үнэ бүхий тоног төхөөрөмжүүдийг акталж устгахыг зөвшөөрсүгэй.

Хоёр: Хөрөнгө акталж устгах ажлын хүрээнд Зоонозын өвчин судлалын төвийн дарга Б.Алтантөгсөд дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай: Үүнд:

2.1. Сумын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах, акталснаас гарах материалыг эргэлтийн хөрөнгөд бүртгэж авахыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3. Энэ тогтоолын биелэлтийг 2018 оны 12 дугаар сард багтаан Орон нутгийн өмчийн газарт ирүүлэх.

Гурав: Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (О.Бат-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

ДАРГА С.СҮХБААТАР

0100293

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн
2018 оны 12 сарын 10-ний өдрийн
120 дугаар тогтоолын хавсралт

Зоонозын өвчин судлалын төвийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй акталж, данснаас хасах хөрөнгийн жагсаалт

| Д/д | Хөрөнгийн нэр | Ашиглалтад орсон огноо | Хэмжих нэгж | Тоо хэмжээ | Нэгжийн үнэ | Балансын үнэ | Хуримтлагдсан элэгдэл | Үлдэгдэл өртөг | Данснаас хасах болсон шалтгаан | Актлах төрөл /1.Устгах 2.Худалдах 3.Сэлбэг материал, хоёрдогч түүхий эд болгон ашиглах 4.Бусад |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Термостат DH-2501 /хөлтэй/ | 1995 он | ширхэг | 1 | 252,000.00 | 252,000.00 | 252,000.00 | - | ашиглахгүй болсон | 1 |
| 2 | Чиглүүлэгч | 2014 он | ширхэг | 1 | 562,000.00 | 562,000.00 | 290,366.77 | 271,633.23 | ашиглалтын явцад эвдэрсэн | 1 |
| 3 | Автомакс SB-1 | 2016 он | ширхэг | 1 | 534,333.00 | 534,333.00 | 356,253.20 | 178,079.80 | ашиглалтын явцад эвдэрсэн | 1 |
| 4 | Canon Sharp AR-158X | 2011 он | ширхэг | 1 | 500,000.00 | 500,000.00 | 500,000.00 | - | эвдэрсэн | 3 |
| 5 | Хар сандал | 2006 он | ширхэг | 2 | 9,617.00 | 19,234.00 | 19,234.00 | - | хугарсан | 1 |
| 6 | Цэнхэр сандал | 2006 он | ширхэг | 1 | 13,040.00 | 13,040.00 | 13,040.00 | - | хэмхэрсэн | 1 |
| 7 | Угаалгын машин | 2005 он | ширхэг | 1 | 223,350.00 | 223,350.00 | 223,350.00 | - | хэмхэрсэн | 1 |
| 8 | Усан ванн | 2007 он | ширхэг | 1 | 610,500.00 | 610,500.00 | 610,500.00 | - | шаардлага хангахгүй | 1 |
| 9 | Цагаан бүрээс 5 ханатын | 2000 он | ширхэг | 2 | 36,000.00 | 72,000.00 | 72,000.00 | - | урагдсан | 1 |
| 10 | Хошлон 5 ханатын | 2006 он | ширхэг | 1 | 16,300.00 | 16,300.00 | 16,300.00 | - | үжирсэн | 1 |
| 11 | Цагаан бүрээс 4 ханатын | 2000 он | ширхэг | 1 | 18,000.00 | 18,000.00 | 18,000.00 | - | урагдсан, үжирсэн | 1 |
| **НИЙТ ДҮН** | | | | | | **2,820,757.00 (хоёр сая найман зуун хорин мянга долоон зуун тавин долоо)** | **2,371,043.97 (хоёр сая гурван зуун далан нэгэн мянга дөчин гурван төгрөг ерэн долоон мөнгө)** | **449,713.03 (дөрвөн зуун дөчин есөн мянга долоон зуун арван гурван төгрөг гурван мөнгө)** | | |